Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 4 дүгээр хавсралт

# НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

(2022 он)

2022 оны 12 дугаар сарын 01

Улаанбаатар хот

| № | Үйл ажиллагаа | № | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх | | | | | |
| 1. | Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт | 1.1. | Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо: | | 55 удаагийн сургалт зохион байгуулагдсан. | 1. Нэг удаагийн сургалтын хугацаа 4 цагаас дээш бол тайлагнана.<br><br>2. Зорилтот түвшин хэсэгт байгууллагын сургалтын төлөвлөгөөнд туссан дүнг бичнэ.<br><br>3. Гадаад улс орон, хилийн чандад хамрагдсан сургалтыг тайлагнана.<br><br>4. Дэлгэрэнгүй |
| | | Үүнээс | Ажлын байран дахь сургалт | | Тайлант хугацаанд 55 удаагийн цахим болон танхимын сургалтад албан хаагчдыг хамруулсан. Үүнд: Удирдлагын академиас зохион байгуулсан “Алсын хараа-2050” цахим сургалтад 3, “Алсын хараа-2050” урт хугацааны бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг олон нийтэд сурталчлах нь сургалтад газрын дарга, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайлал”-ын хөтөлбөрт 1, НЗДТГ-аас зохион байгуулсан “Бодлого төлөвлөлтийн баримт бичгийн танилцуулга” 1 удаагийн цахим сургалтад 13, “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 1 удаагийн сургалтад 3, “Фидикс олон улсын гэрээний эрх зүй” сургалтад 2, “Нийслэлийн богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нь” сургалтад 1, Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад 14, НЗДТГ-ын Хүний нөөцийн | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлт”-ийн 1 удаагийн цахим сургалтад 20, “Төрийн байгууллагад нийтлэг хөтлөгддөг баримт бичгийг боловсруулах арга зүй” 1 удаагийн цахим сургалтад 18, “Хууль, эрх зүйн” 2 удаагийн сургалтад 6, “Төслийн удирдлагын үндэс” 1 удаагийн сургалтад 2, “Төрийн албан хаагчийн манлайлал” 2 удаагийн сургалтад 3, “Бизнес процессын дахин загварчлал” сургалтад 2, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сургалтад 2, “Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжийг дээшлүүлэх нь” 2 удаагийн цахим сургалтад 14, “Харилцан суралцах арга зүй” сургалтад 1, Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн Пүрэв гараг бүр зохион байгуулдаг 7*4*10 29 удаагийн арга зүйн сургалтад нийт албан хаагчдыг 29 удаа хамруулсан. Байгууллагаас дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд: шинэчлэн батлагдсан “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн танилцуулга, “Жендерийн эрх тэгш байдал” цахим сургалтад 22, Боловсролын их сургуультай хамтран зохион байгуулсан “Үндэсний бичиг” сургалтад 14, Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулсан “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, галын багаж хэрэгслийг ашиглах тухай” сургалтад 21, Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Авлигын гэмт хэргийн хуульчлагдсан байдал” сэдэвт сургалтад 33 албан хаагч тус тус хамрагдсан байна. Нийт 55 удаагийн сургалтад давхардсан тоогоор 223 албан хаагч хамрагдсан байна. | судалгаа мэдээллийг тайланд хавсаргасан байна. |
| | | | Мэргэшүүлэх сургалт | 2 | Мэргэшүүлэх 4 сургалтад холбогдох албан хаагчид хамрагдсан. Үүнд:<br>1.Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх А3 гэрчилгээ олгох сургалтад 11 албан хаагч хамрагдсан. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2.2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 05 дугаар сарын 12-ны өдрүүдэд НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн төв, Сингапур улсын "Өружин" сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан "Сургалтын дизайн болон суралцахуйн дизайн" гэрчилгээ олгох сургалтад 1 албан хаагч хамрагдсан.<br>3.Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хувийн зардлаар 2 албан хаагч,<br>4.Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хувийн зардлаар 3 албан хаагч тус тус хамрагдсан. | |
| | | | Туршлага солилцох арга хэмжээ | - | - | |
| | | | Бусад | - | - | |
| | | 1.2 | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | - | Нийт 35 албан хаагч сургалтад хамрагдсан. | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | - | Нийт 35 албан хаагчаас 54.3% буюу 19 нь эмэгтэй албан хаагч байна. | |
| | | | Эрэгтэй албан хаагч | - | Нийт 35 албан хаагчаас 45.7% буюу 16 эрэгтэй албан хаагч байна. | |
| | | | Удирдах албан тушаалтан | - | Сургалтад хамрагдсан албан хаагчдын 14.3% буюу 5 нь удирдах албан тушаалтан байна. | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | - | Сургалтад хамрагдсан албан хаагчдын 85.7% буюу 30 нь гүйцэтгэх албан тушаалтан байна. | |
| | | 1.3 | Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал:<br>Нийт албан хаагчдад эзлэх хувь | 90-ээс дээш | Газрын одоо ажиллаж буй 35 албан хаагчаас 35 буюу 100% сургалтад хамрагдсан байна. | |
| 2. | Албан хаагчдыг | 2.1. | Нийт гадаад сургалт, | - | Гадаад сургалт, семинар, зөвлөгөөнд хамрагдах төсөв батлагдаагүй. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт | | семинар, зөвлөгөөний тоо | | | |
| | | 2.2. | Хамрагдсан нийт албан хаагчдын тоо: | - | - | |
| | | Үүнээс | Эмэгтэй албан хаагч | - | - | |
| | | | Эрэгтэй албан хаагч | - | - | |
| | | | Удирдах албан тушаалтан | - | - | |
| | | | Гүйцэтгэх, туслах албан тушаалтан | - | - | |
| | | 2.3. | Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь | 20-оос дээш | - | |
| 3. | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн | 3.1. | Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | 0 | Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн арга хэмжээний талаарх 2021-2024 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр, түүний хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр батлуулсан.<br>2022 оны байгууллагын үйл ажиллагааны жилийн нийт төсөвт сургалт хөгжил, хичээл үйлдвэрлэлийн зардалд мөнгө батлагдаагүй тул зарцуулсан зардалгүй байна. | Тайлант оны гүйцэтгэлээр |
| | | 3.2. | Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь | 15-аас доош | Газрын хэмжээнд 2022 оны жилийн эцсийн байдлаар албан тушаалаас чөлөөлөгдсөн 18 албан хаагч, шинээр томилогдсон 15 албан хаагч, бусад төрийн байгууллагад шилжин ажилласан 3 албан хаагч байна. Нийт батлагдсан 40 орон тооноос чөлөөлөгдсөн | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон шилжин ажилласан 21 албан хаагч байгаа нь хүний нөөцийн хөдөлгөөн 52.5%-д хийгдсэн байна. | |
| | | | Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах | | | |
| 4. | Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | 4.1. | Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь | 77.15% | Байгууллагын 2022 оны үйл ажиллагааны жилийн нийт төсвийн 77.15% нь буюу 542,041.3 мянган төгрөгийг үндсэн цалин, нэмэгдэл, урамшуулалд зарцуулахаар төсөвлөснөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн гүйцэтгэлээр 522,477.5 мянган төгрөг буюу 96.4%-ийг үндсэн цалин, нэмэгдэл, урамшуулалд зарцуулаад байна. | Тайлант оны гүйцэтгэлээр |
| | | 4.2. | Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг) | 7,0 | Нэгж албан хаагчид хоол, унааны нэмэгдэл 1 хоногт 7000 төгрөг олгохоор төсөвлөсөн. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн гүйцэтгэлээр 59,661.0 мянган төгрөгийг 35 албан хаагчийн хоол, унааны нэмэгдэлд олгосон. | Хоногт олгохоор тогтоосон дүн |
| 5. | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх | 5.1. | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж) | 80-аас дээш | Нийслэлийн засаг захиргааны 4-р байрны менежертэй хамтран ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээг тогтмол гүйцэтгүүлж албан хаагчдын ажиллах нөхцөл, таатай орчинг бүрдүүлэх, цэвэрлэгээ үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд анхаарч ажилласан. Тус байрнаас ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааг 1 удаа авсан бөгөөд албан хаагчдын 91% нь цэвэрлэгээ, үйлчилгээ тогтмол хийгдэж, албан хаагчдын ажиллах нөхцөл, таатай орчинг бүрдүүлсэн гэж үнэлсэн. | Асуулгын агуулга, хэлбэр нь жишиг загварт нийцсэн байна |
| 6. | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | 6.1. | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд) | 1-ээс дээш | 2022 төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн саналд албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар төсөөлсөн боловч байгууллагын үйл ажиллагааны жилийн төсөвт хянаж, батлаагүй байна. | Төрөлжсөн болон багц шинжилгээ |
| | | 6.2. | Албан хаагчдын хамрагдалт | | | Сайн дураар хамрагдах |
| 7. | Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах | 7.1. | Албан хаагчдын нийгмийн асуудалд | - | Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр, түүний хүрээнд 2022 онд хэрэгжүүлэх ажлын | Тайлант оны гүйцэтгэлээр |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | чиглэлээр зарцуулсан зардал | | зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг) | | төлөвлөгөөнд тусгасны дагуу нийгмийн асуудалд жилийн эцсийн байдлаар 5.0 сая төгрөг зарцуулсан. | |

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ — Г.ЭНХТАЙВАН

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — С.ОЮУНЦЭЦЭГ

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ — З.ОТГОНБАТ

ТАЙЛАГНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — С.РЭНЦЭНМАА